

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /Маягт2/		
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.		
Тайлагнах хугацаа:		2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр/
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар		Техник импорт ХК УБГД:9010001041 ҮЦК:441 Утасны дугаар: (+976) 70001830
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр		Монголын хөрөнгийн бирж ХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар		Гадаад худалдаа, барилгын материалын худалдаа
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг		144,675,5
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр		Санхүү, бизнес хариуцсан албаны захирал С.Дашдулам ТУЗ-ын н.б.д О.Бүжинлхам Хянасан: Гүйцэтгэх захирал Д.Ганцэцэг
1.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Тайланг хавсаргав.
	Орлогын тайлан	Тайланг хавсаргав.
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Тайланг хавсаргав.
	Мөнгөн гүйлгээний тайлан	Тайланг хавсаргав.
2.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт	
	Тайлант хугацаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу Техник импорт ХК-ийн ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо 2026 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд: 1. Дотоод аудитын албаны хагас жилийн ажлын тайлан 2. ТУЗ-ын дэргэдэх Аудитын хорооны хагас жилийн ажлын тайлан 3. Техник импорт ХК-ийн хагас жилийн санхүүгийн тайлан ТУЗ-ын дэргэдэх Аудитын хорооны хурлаас компанийн Дотоод аудитын албаны хагас жилийн ажлын тайланд “Хангалттай сайн” үнэлгээ өгч, компанийн 2026 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг	

	хянан хэлэлцэж “Техник импорт ХК-ийн 2026 оны хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хамаарах бүх өр төлбөр, орлого, зардал, хөрөнгө нь МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлж тусгагдсан байна” гэж дүгнэсэн.	
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинэжилгээ, орлого, зарлага, ангийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт	
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	1. Цэвэр хүүний маржин (NIM) 2% 2. Нийт хөрөнгийн өгөөж (ROA) 1,25% 3. Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 1,2% 4. Нийт активын өөрчлөлт 10,7% 5. Өөрийн хөрөнгө /Нийт хөрөнгө/ 0,01% 6. Өр төлбөр / Нийт хөрөнгө/ 0,7% 7. Хөрвөх чадвартай хөрөнгө 1,35%
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, хэлбэрт өөрчлөлт ороогүй бөгөөд хэрэглээ /ус, дулаан, түлш шатахуун/-ний болон хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн нэмэгдэл, инфляцийн өсөлтөөс шалтгаалан бэлэн мөнгөний хомсдол үүсч харилцагч байгууллагууд, иргэдийн худалдан авах чадвар буурсан нь компанийн борлуулалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж өр авлага үүсэх улмаар эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр дутагдах эрсдлийг бий болгож бараа материалын захиалга хийх, нийлүүлэх ажиллагаа удаашрах, хойшлогдоход нөлөөлөх хүчин зүйлс болсон. Компанийн удирдлагаас дээрх хүчин зүйлсийг харгалзан үзэж компанийн аливаа үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үйл ажиллагааны зардлуудыг тодорхой чиглэлээр ангилж хэрэгжилтэнд хяналт тавих, санхүүгийн сахилга бат, хяналтыг сайжруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой шаардлагатай арга хэмжээнүүдийг авч удирдлагаар ханган үр дүн, хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан.
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Тайлант хугацаанд санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй болно.
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	Байхгүй	

5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл
	Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлээгүй тул татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй.
6.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл
	Компанийн удирдлагын бүтэц, үйл ажиллагаа 1. Хувьцаа эзэмшигчдийн хурал 2. Төлөөлөн удирдах зөвлөл 3. Гүйцэтгэх удирдлага 1. Хувьцаа эзэмшигчдийн хурал Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага юм. Холбогдох хууль, журамд заасны дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөл санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулдаг. Тайлант хугацаанд компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр холбогдох хууль, журмын дагуу амжилттай зохион байгуулж хуралдуулсан. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комисс Техник импорт ХК-ийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд зориулж Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иас ирүүлсэн “Техник импорт ХК-ийн үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй болон хураангуй судалгаа”-ны дагуу ХЭХ-д оролцох эрх бүхий Хувьцаа эзэмшигчдийг бүртгэж, баталгаажуулсан. Компаниас гаргасан нийт энгийн хувьцааны тоо 1,446,755 ширхэг бөгөөд 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн бүртгэлийн өдрөөр тасалбар болгон гаргасан “Техник импорт ХК-ийн үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй болон хураангуй судалгаа”-аар 468 хувьцаа эзэмшигч компанийн хувьцаа эзэмшигчээр бүртгэгдсэн. ХЭХ-ын Тооллогын комисс Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 98,8% нь буюу компанийн дүрэмд заасны дагуу нийт хувьцаа эзэмшигчдийн 60%-иас дээш хувьцаа эзэмшигчид оролцсоныг үндэслэн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсон. ХЭХ-д саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид оролцсоноос гадна ТУЗ-ын хараат болон хараат бус гишүүд биечлэн оролцож хурлын хэлэлцэх асуудлаар хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултанд хариулах, тайлбар, тодруулга хийж хууль, журамд заасан эрх, үүргээ хэрэгжүүлж ажилласан. ХЭХ-ын дэгийн дагуу 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараахь асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд: 1. 2025 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын гаргасан дүгнэлт 2. 2025 оны ногдол ашгийн талаар ТУЗ-аас гаргасан шийдвэр 3. 2025 оны компанийн жилийн үйл ажиллагааны тайлан 4. 2026 оны компанийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө 5. 2025 оны ТУЗ-ын үйл ажиллагааны тайлан 6. 2026 оны компанийн ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүдийг сонгох ТУЗ-ын дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо хуралдаж Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасны дагуу 2025 оны ТУЗ-ын гишүүдийн ажлын тайланг үндэслэн 2026 оны ТУЗ-ын гишүүнээр Ж.Баярсайхан, Б.Батсайхан, Б.Нарантуяа, Т.Тунгалаг, Д.Баяраа, Э.Батболд, Ж.Уртнасан, С.Бүжинлхам, Г.Уран-Өлзий нарыг дахин сонгох санал гаргаж ХЭХ-д нэр дэвшүүлэхээр шийдвэрлэсэн. Компанийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын дагуу Хувьцаа эзэмшигчид ТУЗ-ын дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос гаргасан саналыг хэлэлцэж компанийн засаглалын сургалтанд хамрагдсан гэрчилгээтэй, Компанийн тухай хууль, компанийн Дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тус тус заасан шаардлагуудыг бүрэн хангасан, 2025 онд ТУЗ-ын гишүүнээр амжилттай сайн ажилласан ажлын үзүүлэлт, үнэлгээтэй дараах гишүүдийг 2026 оны компанийн ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүнээр сонгож баталсан. Үүнд: 1. ТУЗ-ын хараат бус гишүүнээр Ж.Баярсайхан, Б.Батсайхан, Б.Нарантуяа нарыг, 2. ТУЗ-ын ердийн гишүүнээр Т.Тунгалаг, Д.Баяраа, Э.Батболд, Ж.Уртнасан, С.Бүжинлхам, Г.Уран-Өлзий нарыг; Мөн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороог тус тус байгуулж бүрэлдэхүүнийг томилсон. ХЭХ-ын Тооллогын комисс Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлуудаар шийдвэр

гаргуулахтай холбогдуулан хэлэлцсэн асуудлуудаас ТУЗ-ын гишүүдийг сонгох асуудлыг кумулятив аргаар, бусад хэлэлцсэн асуудлыг саналын хуудсаар санал авч, дүнг нэгтгэн гаргаж Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсан.

Хуралд оролцсон нийт Хувьцаа эзэмшигчид хурлаар хэлэлцсэн асуудлуудыг бүрэн дэмжиж хурлаас гарах шийдвэр, тогтоолын төслийг 100%-ийн саналаар баталж шийдвэрлэсэн.

ХЭХ-аас гаргасан тогтоол шийдвэр, хурлын тэмдэглэл, хурлын холбогдох баримт материалыг холбогдох хууль, журамд заасан хугацаанд СЗХ, МХБ ХК-д хүргүүлж биржийн цахим хуудсанд байршуулж нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлж ажилласан.

2. Төлөөлөн удирдах зөвлөл

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл юм.

Холбогдох хууль, журмын дагуу компанийн ТУЗ-ын гишүүдийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас, ТУЗ-ын даргыг ТУЗ-ын нийт гишүүдийн олонхийн саналаар сонгож баталдаг.

2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас 9 нэр дэвшигчийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгож томилсон ба 9 гишүүнээс 3 гишүүнийг ТУЗ-ын хараат бус гишүүнээр, 6 гишүүнийг ТУЗ-ын ердийн гишүүнээр сонгосон.

ТУЗ-ын гишүүдийг хүйсээр ангилбал 5 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй гишүүн байна.

Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 9 гишүүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд Компанийн тухай хууль, компанийн Дүрэм, ТУЗ-ын үйл ажиллагааны журамд заасны дагуу дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд:

1. Ногдол ашиг хуваарилах тухай /2026.02.13 №01/
2. Элчин сайдын яаманд тодорхойлолт гаргах тухай /2026.02.26 №02/
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай /2026.03.09 №03/
4. Элчин сайдын яаманд тодорхойлолт гаргах тухай /2026.05.21 №04/
5. Баталгаа гаргах тухай /2026.06.10 №05/
6. Тодорхойлолт гаргах тухай /2026.07.03. №06/

ТУЗ-ын 6 удаагийн хуралд 9 гишүүн оролцож хурлаар хэлэлцсэн асуудлыг 100%-ийн саналаар баталж шийдвэрлэсэн.

Мөн тайлант хугацаанд холбогдох хууль, журмын хүрээнд ТУЗ-ын дэргэдэх Хороод өөрсдийн чиг үүргийн дагуу холбогдох асуудлаар хуралдаж үнэлэлт, дүгнэлт гаргаж ажилласан. Үүнд:

1. ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо

- Компанийн Дотоод аудитын албаны 2025 оны жилийн ажлын тайланг хэлэлцэх;
- 2025 оны нэгж хувьцаанд ногдол ашиг олгох эсэх, компанийн 2025 оны үйл ажиллагааны болон жилийн эцсийн санхүүгийн тайланг хэлэлцэх;
- 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх компани сонгох;
- ТУЗ-ын Аудитын хороо, Дотоод аудитын албаны 2026 оны хагас жилийн ажлын тайланг хэлэлцэх;
- Компанийн хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх;
- Компанийн “Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам”-ын хэрэгжилт, 2026 оны хагас жилийн журмын хэрэгжилтийн тайланг хэлэлцэх;

2. ТУЗ-ын дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо

- 2026 оны ТУЗ-ын гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэх;

3. ТУЗ-ын дэргэдэх Цалин, урамшууллын хороо

- ТУЗ-ын 2025 оны төсвийн зарцуулалтын тайлан, 2026 оны ТУЗ-ын төсвийг хэлэлцэх;
- Компанийн Гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн саналын дагуу компанийн ажилтнуудын цалин урамшууллын бодлого түүнтэй холбоотой дүрэм, журмын нийцэл, хэрэгжилтэнд хяналт тавих асуудлыг хэлэлцэх;

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл ТУЗ-ын төсвийн дагуу “ТУЗ-ын 2026 оны сургалтын төлөвлөгөө”-г баталж төлөвлөгөөний дагуу шаардлагатай сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулж ажилласан.

Холбогдох хууль, журамд заасны дагуу компанийн ТУЗ-аас тухай бүр мэдээлэх мэдээллийг заасан хугацаанд зохих журмын дагуу СЗХ, МХБ ХК-д хүргүүлж, биржийн болон компанийн цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлж ажилласан.

Тайлант хугацаанд Техник импорт ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн үнэлгээний дагуу тайланг гаргаж холбогдох нотлох баримтын хамт СЗХ-нд тайлагнаж ажилласан.

Мөн Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл Санхүүгийн зохицуулах хорооны үнэлгээний тайлангаар өгсөн үүрэг, даалгавар, заавар, зөвлөмж, холбогдох хууль, дүрэм, журамд заасан шаардлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан ба хэрэгжүүлсэн ажлын тайланг холбогдох нотлох баримт материалын хамт СЗХ-нд хүргүүлж тайлагнаж ажилласан.

3. Гүйцэтгэх удирдлага

Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг компанийн Гүйцэтгэх захирал удирдан зохион байгуулж ажилладаг.

Компанийн Гүйцэтгэх захирлаар 2006 оноос хойш Дашдондог овогтой Ганцэцэг ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл компанийн Гүйцэтгэх удирдлагатай “Гүйцэтгэх

	удирдлагыг хэрэгжүүлэх гэрээ”-г байгуулан тус гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна. Тайлант хугацаанд компанийн бүтцэд ямар нэгэн өөрчлөлт ороогүй бөгөөд компанийн бүтэц, зохион байгуулалтын дагуу Гүйцэтгэх удирдлага компанийн дараах нэгж, албадын үйл ажиллагааг удирдлагаар хангаж, үйл ажиллагааны чиглэлийн дагуу үүрэг, даалгавар, зөвлөмж өгч хэрэгжитэнд хяналт тавьж үнэлгээ, дүгнэлт өгч ажилласан. Үүнд: 1. Гүйцэтгэх захирал 2. Дотоод аудитын алба 3. Захиргаа, хүний нөөцийн алба 4. Дэмжих үйлчилгээний алба 5. Инженер техникийн алба 6. Санхүү, бизнесийн алба 7. Бизнес хөгжлийн алба Тайлант хугацаанд компанийн Гүйцэтгэх удирдлага 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас баталсан үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө болон бусад асуудлаар ХЭХ-аас баталсан шийдвэр тогтоолын биелэлтийг хангах, ТУЗ-тай байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүргийн хүрээнд компанийн үйл ажиллагааг доголдолгүй, үр ашигтай, хэвийн явуулахтай холбоотой ажлуудыг удирдан зохион байгуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. Компанийн ХЭХ-аас баталсан 2026 оны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдуулан компанийн оролцогч талуудтай харилцах хүрээнд албан бичиг солилцох, биечлэн уулзах хэлбэрээр хамтран ажиллаж тэдний хүсэлт, шаардлагад нийцүүлэн зохих журмын дагуу шаардлагатай үйлчилгээ, бараа, материалыг заасан хугацаанд нь нийлүүлж хамтран ажилласан. Мөн компанийн үйл ажиллагааг хэвийн, доголдолгүй явуулах зорилгоор компанийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх, компанийн хэмжээнд ISO 9001 чанарын менежментийн тогтолцооны хэрэгжилтэнд хяналт тавьж сайжруулах арга хэмжээ авч чанаржуулах, үр дүнг хангаж ажиллах чиглэлээр албадын дарга нар болон дотоод аудитын албанд хугацаатай үүрэг, даалгавар өгч үр дүн, хэрэгжилтийн талаар ажлын тайлан авч, шаардлагатай асуудлаар хамтран ярилцаж холбогдох зөвлөмж, удирдлагаар хангаж ажилласан. Тайлант хугацаанд компанийн Дотоод аудитын алба нь Гүйцэтгэх удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу “Санхүүгийн дотоод аудитын журам”, “Чанарын дотоод аудитын журам”-аар олгосон чиг үүргийн хүрээнд компанийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд аудит хийж ажлын үр дүнгээ ТУЗ-ын Аудитын хороо болон Гүйцэтгэх удирдлагад танилцуулж ажилласан.
6.	<i>Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл</i>
	Тайлант хугацаанд Зохицуулагч байгууллагуудаас албан бичиг, и-мэйлээр ирүүлсэн зөвлөмж, үүрэг даалгавруудыг биелүүлж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. Тухайлбал: Монголын хөрөнгийн бирж ХК 1. 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн Монголын хөрөнгийн бирж ХК-иас “Хамтран ажиллах тухай” 01/50 дугаар албан бичиг, 2026 оны 02 дугаар сарын 14-ний болон 2026 оны 05 дугаар сарын 06, 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн “Тайлан ирүүлэх тухай” албан бичгээр өгсөн зөвлөмж, үүрэг даалгаврыг заасан хугацааны дотор хэрэгжүүлж ажилласан. Үүнд: ➢ Компанийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан ➢ 2025 оны ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-ын шийдвэр ➢ Компанийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдэл ➢ Компанийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэр, хурлын тэмдэглэл, холбогдох бусад хавсралт баримт материалууд ➢ 2025 оны компанийн жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын байгууллагын дүгнэлт ➢ 2025 оны жилийн үйл ажиллагааны тайлан ➢ Компанийн 2026 оны хагас жилийн санхүүгийн тайлан ➢ Компанийн 2026 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан ➢ 2025 оны үнэт цаас гаргагчийн жилийн үйлчилгээний хөлс төлөх /МХБ ХК/ ➢ 2025 оны “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт”-ийн тайлан ➢ Ногдол ашгийн хуваарилалтын тайлан

2. 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр МХБ ХК-иас ирүүлсэн “Тоон гарын үсгийн тухай” албан бичгээр тавьсан шаардлага, хүсэлтийн дагуу компанийн тоон гарын үсгийн талаарх мэдээллийг МХБ ХК-д хүргүүлсэн.
3. 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдөр МХБ ХК-ийн “Сургалтын тухай” албан бичгийн дагуу МХБ ХК-иас зохион байгуулж явуулсан биржийн цахим сайтанд мэдээлэл оруулах тухай танилцуулга, заавар, зөвлөмж өгөх сургалтанд хамрагдаж оролцсон.
4. 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн МХБ ХК-ийн “Хамтран ажиллах санал хүргүүлэх тухай” албан бичгээр ирүүлсэн МХБ ХК-ийн “Сургалт, үйлчилгээ, мэдээллийн төв”-ийн танхимын талаарх мэдээллийг удирдлагад танилцуулсан.

Санхүүгийн зохицуулах хороо

5. ХК-иудын “Компанийн засаглалын кодексе”-ийн хэрэгжилтийн 2025 оны нэгдсэн үнэлгээний тайланг гаргахтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн албан бичгийн дагуу компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн шинэчилсэн тайланг нотлох баримтын хамт 2026 оны 01 дүгээр сарын 15-ны дотор СЗХ-нд хүргүүлж тайлагнасан.
6. Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн “Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай” 9/77 дугаар албан бичгээр 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах, ТУЗ-ын хараат болон хараат бус гишүүдийг сонгох, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг хүргүүлэх, хугацаат тайлагналын болон тухай бүр нийтэд мэдээлэх мэдээллийн талаар холбогдох хууль тогтоомж, журмаар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулахтай холбогдуулан өгсөн зөвлөмж, үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь хэрэгжүүлж ажилласан.
7. Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн “Хэлэлцүүлгийн мэдэгдэл хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу Хорооны цахим хуудаст байршуулсан “Хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилах журам”-ын төсөлтэй танилцаж, 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Хорооноос зохион байгуулж явуулсан тус журмын төслийн олон нийтийн хэлэлцүүлэгт оролцсон.
8. Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдөр ирүүлсэн албан бичгийн дагуу “Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад бэлэглэлээр, өв залгамжлалаар шилжүүлэх тухай журам”, “Хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, хадгалах, арилжих, өмчлөх эрх шилжүүлэх тухай” журмуудын төсөлтэй танилцаж, 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн Лхагва гарагт СЗХ-ны “Санхүүгийн хүртээмжийн танхим”-д болсон журмын төслүүдийн олон нийтийн хэлэлцүүлэгт оролцсон.
9. Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 3/2360 дугаар албан бичгийг ТУЗ-ын дарга болон ТУЗ-ын дэргэдэх Хороодын дарга нарт танилцуулж, тус албан бичгээр өгсөн зөвлөмж, шаардлагын дагуу 2026 оны компанийн ТУЗ-ын нарийвчилсан ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, дотоод аудитын албаны үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэнд хяналт тавих чиглэлээр холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж хяналт тавьж ажилласан.
10. Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн албан бичгийн дагуу 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдөр СЗХ, ЕТГ, мэргэжлийн хороодоос хамтран зохион байгуулсан Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санхүүгийн зах зээлийн салбарын төлөөлөлтэй хийх уулзалтанд компанийн Гүйцэтгэх захирал, ТУЗ-ын нарийн бичгийн дарга оролцсон.

Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл:

Тайлант хугацаанд СЗХ-ноос компанийн 2026 оны “Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал хянасан тухай” албан бичгийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 9/2404 дугаар албан бичгээр ирүүлсэн бөгөөд тус албан бичгээр Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэхь заалтыг хангасан байна” гэж дүгнэсэн.

Тайлант хугацаанд СЗХ-ноос гаргасан 2025 оны “Компанийн засаглалын кодексын хэрэгжилт”-ийн нэгдсэн үнэлгээний тайлангаар компани 4-р байранд орсон.

Тайлант хугацаанд МХБ ХК биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын 2025 оны хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн нэгдсэн судалгааг гаргаж дүгнэсэн ба энэхүү судалгаагаар компани нь 100%-ийн үнэлгээтэй дүгнэгдсэн.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр:

Албан тушаал: “Техник импорт ХК-ийн

Гүйцэтгэх захирал Д.Ганцэцэг

Гарын үсэг:



(Тамга/тэмдэг)

Овог, нэр:

Албан тушаал: “.....” .. аудитын компанийн
гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: О.Бүжинлхам

Албан тушаал: ТУЗ-ын н.б.д

Гарын үсэг: О. Бүжинлхам

2026.07.31

